

ШОГ, ХОШИН НИЙТЛЭЛИЙН БИЧЛЭГИЙН
ТӨРӨЛ, ЗҮЙЛИЙН ОНЦЛОГ

Н. Мөнхзориг*

* "Идэр" дээд сургууль, Монгол хэл, сэтгүүл зүйн тэнхимийн эрхлэгч, доктор

Түлхүүр үг: шог, хошин нийтлэл, "Хүмүүжил жигшил", "Матар", "Тоншуул" сэтгүүл, шог, хошин нийтлэлийн сэдэв, бичлэгийн төрөл зүйл, шог, хошин нийтлэлчид, тэдний бичлэгийн уран чадвар

Сэтгүүл зүйн бичлэгийн төрөл, зүйл, хэлбэрүүдийн нэг адил шог, хошин бичлэгийн төрөл, зүйлүүд ялгаатай болон нийтлэг талуудтай байдаг.

Өдөр тутмын болон нийгмийн амьдралд оршиж байгаа гэм дутагдлыг шог, хошин бичлэгийн төрөл, зүйл хэр далайцтай, хэрхэн тусгаснаараа ялгардаг. Тухайлбал: хошин зүйр үг, хошин оньсого, шог яриа буюу онигоо, ёгт үлгэр, шог, хошин мэдээ, ёргио үг, элэглэл гэх мэт бичлэгийн зүйл багахан үйл явдал, асуудлыг тусгасан байдаг бол шог найруулал, улс төрийн шог зэрэг томоохон зүйлүүд нийгэм, амьдралд оршиж байгаа гэм дутагдал, хоцрогдол, согогыг олон талаас нь үл үндэстэй авч үзэж, гүн гүнзгий үнэлэлт дүгнэлттэйгээр хошигнон шоглосон байдаг. Тэгвэл нийгэм, цаг үеийн хөгжилд саад болж, чөдөр тушаа болж буй гэм дутагдлуудыг шог, хошин

бичлэгийн бүх зүйл нэгэн адил тусгагддаг хамааралтай бичлэг юм.

«Сонины бичлэгийн төрөл, зүйл гарын авлагад шог, хошин нийтлэлийн шог мэдээ, элэглэл, ёргио үг, ёгт үлгэр, шог найруулал, улс төрийн шог гэж ангилсан байдаг¹. Бичлэгийн эдгээр зүйл нь нийтлэл-уран сайхны төрөлд багтдаг. Эдгээрийн заримаас өгүүлэе.

Шог найруулал. Шог найруулал Өрнөдийн сэтгүүл зүйд «фельетон» гэдэг. Анхандаа францын «feuilleton» нь «сонинд хавсаргасан хуудас» гэсэн утгатай байжээ. Анхны фельетон «Журналь дэ деба» сонины 1800 оны 1 дүгээр сарын 28-ны дугаарт гарсан байна. Тус сонин тэр өдөр уртасгасан форматтай хэвлэгдсэн бөгөөд доод хэсгийг нь «фельетон» гэсэн байв. Үндсэн сонин болон фельетон хэсгийг зураасаар заагласан байжээ. Анхны фельетонуудад элдэв төрлийн зар, театрын хөтөлбөр, шинэ загварын тухай мэдээлэл, уншигчдаас ирүүлсэн үгийн оньсого зэргийг нийтэлж байснаа яваандаа жүжиг, ном хэвлэлийн талаарх товч шүүмж, уншигчдын санал сэтгэгдэл нийтлэгдэх болжээ. Аажимдаа шүүмжүүд хорон үгтэй, шог хошиноор бичигдэх болж, улс төрийн

өгт сануулгыг битүү дохиогоор өгөх болсон нь уншигчдын таашаалыг хүлээжээ. Гэхдээ эдгээр нийтлэлийг анхны фельетон буюу шог найруулал байсан гэж үзэх нь учир дутагдалтай юм. «Фельетон» хэмээх нэр томъёо үүсэхээс бүр өмнө нийгмийн сөрөг үзэгдлийг шог аргаар илчилдэг бичлэгийн төрөл, зүйл Өрнөдийн сэтгүүл зүйд дэлгэрсэн байжээ².

Судлаач М. Зулькафиль шог найруулал нь амьдралын сөрөг баримт, үзэгдэл, үйл явдал, асуудлыг нийтлэл-уран сайхны хосолмол шинжээр дамжуулан шог, хошин өнгө аясаар дүрслэн харуулах зорилго бүхий бичлэгийн зүйл болохыг тодорхойлоод, дараах онцлог шинжүүдийг нь дурджээ: «... Бодит баримт, үзэгдлийг нэгтгэн дүгнэж, уран сайхны шог хошин дүр бүтээх зорилгыг агуулдаг; оршиж буй дутагдал, доголдлыг илчлэн шүүмжилж, баримтаа уран сайхны аргаар боловсруулдаг; бүтээсэн уран сайхны шог хошин дүр нь ямагт бодит хүн байдаг; баримтыг нэгтгэн дүгнэхдээ тэдгээрийн дотоод мөн чанар, хандлагыг нээн илрүүлж, дутагдал доголдлын шалтгаан, үр дагаварыг харуулдаг; тусгаж буй сэдвийн дотоод мөн чанарт нэвтэрч, илчлэх зорилгоор хэтрүүлэл, зүйрлэл, адилтгал, элэглэл, егөөдөл, ингүүн үг зэрэг уран сайхан, шог хошин найруулгын элементүүд, хэрэглүүрүүдийг өргөн ашигладаг; зохиогч санаа бодлоо оновчтой илэрхийлэх, буруушааж байгаа зүйлдээ хэрхэн хандаж байгаагаа илтгэх зорилгоор инээдэмт зүйл, элементүүдийг ашигладаг»³ гэжээ.

Шог найруулал бол хэн дуртай хүний шүүрч аваад биччихдэг зүйл биш юм. Учир нь авьяасаас гадна шог,

хошины мэдрэмж гэдэг сэтгүүлч болгонд заяагддаггүй «зургаа дахь мэдрэхүй» шаардагддаг⁴. Тийм ч учраас шог найруулал бичдэг сэтгүүлч цөөхөн байдаг.

Бичлэгийн бусад төрөл, зүйлээс шог найруулал хоёр онцлог шинжээрээ эрс ялгардаг. Юуны түрүүнд шог найруулал сэтгэл хөдлөл бүхий, өгүүлж буй юм, үзэгдэлд зохиогчийн хандаж буй хандлагыг барим тавим илэрхийлсэн өнгө аяс бүхий найруулгаараа ялгаатай⁵. Удаах шинж нь шог найруулал бичиж буй сэтгүүлч шаардлагатай гэж үзвэл зарим нэг баримт, дүрийг өөрөө зохиож, санаанаасаа дэлгэрүүлж болдог оршино⁶.

Шог найрууллыг шог өгүүллэгтэй андуурч хутгах тал бий. Хэдийгээр бичлэгийн энэхүү хоёр зүйл олон шинж, талаараа адил төстэй боловч зарчмын ялгаатай. Шог найруулал нь сэтгүүл зүйн бичлэгийн зүйл болохынхоо хувьд бодит баатрын зан авир, ёс суртахуун, соёл хүмүүжлийн доголдлыг харуулдаг, харин утга зохиолын нэг төрөл шог өгүүллэгт адилхан уран сайхны шог, хошин дүр бүтээдэг боловч тэр нь зохиомол байдаг.

Судлаач Л. Норовсүрэнгийн тэмдэглэснээр: «Манай хэвлэлийн шог найруулал нь ардын аман зохиолын шог хошин зүйлүүдээс эхтэй бөгөөд гол төлөв явган үлгэрийн хэлбэртэй бяцхан шогийн суурин дээр үүссэн юм... 1921-1940 оны хэвлэлүүдэд шог шүлэг, үлгэр өгүүллэг голлож байсан бол 1940-1960 оны хооронд шог найруулал бие даасан бичлэгийн зүйл болж төлөвшжээ. Монголын сэтгүүл зүйн шог найрууллын үүсэл, хөгжлийн түүх нь хар овоохойноос өөр оромжгүй,

хайдаг ямаанаас өөр малгүй, харанхуй бүдүүлэг байснаа арыг бүрхсэн адуу малтай, гэрийг дүүргэсэн түвшин жаргалтай болж, гэгээрч соёлжих хүртэл манай ард түмний ахуй, ухамсарт гарсан их өөрчлөлтийн замд саад тотгор болсон хоцрогдолтой хийсэн тэмцлийн түүх юм»⁷.

1990 оноос хойшх үеийн «Тоншуул» сэтгүүлд ч шог найруулал өөрийн гэсэн орон зайг эзэлсээр байв. Тус сэтгүүлд А. Амарсайханы «Цагдаагийн гэргий миний эцсийн өчил» (2006, №09), «Монгол банхрын хуцалт» (2006, №13, 14), М. Гүрсэдийн «"Нисдэг таваг" хөдөлгөөнийхөн» (2006, №18), «"Хариуцлага"-ыг халъя» (2006, №13, 14), «Дэлхийд ганцхан наадамч Монгол» (2006, №01), Д. Баяс-галангийн «Үл үзэгдэгч хүн» (2006, №09), «Нэгэн хөршийн тухай» (2006, №18), «Янхан эх ба зандан түшмэд» (2006, №13, 14), «Бат-Эрдэнэ аварга сумод түрүүлсэн нь» (2006, №13, 14), «"Зүйлийн хувьсгал"» (2006, №16, 17), «Шүүрэн шанага үйлдвэрлэгчийн гомдол» (2006, №11), «Харь гаригийн хүн Монголд айлчилсан нь» (2006, №02), Н. Даваадашийн «"Янхантай улс төр"-ийн шинэ лекц» (2006, №11), «Яруу найргийн тухай шинэ номлолын удиртгал» (2006, №12), С. Баярхүүгийн «Чингис» (2006, №09), Ц. Ганбаатарын «Сэлэнгийг жолоодох сургаар» (2006, №12), Н. Пүрэвсүрэнгийн «Боовтой чавганц» (2006, №02), Г. Рагчаагийн «Самар бол завшигчдыг баяжуулагч»

(2004, №16) гэх мэт шог найруулал нийтлэгджээ.

Эдгээр шог найруулалд аливаа ээдрээ, гэм дутагдлыг хайр найргүй элэглэн шоглож, илчлэн шүүмжилжээ. А. Амарсайханы «Цагдаагийн гэргий миний эцсийн өчил» шог найруулалд Ж. Батзандан, О. Магнай, Г. Баасан тэргүүнтэй болон бусад хөдөлгөөн Ерөнхийлөгч Н. Энхбаяр, Ерөнхий сайд

«
Шог найруулал нь сэтгүүл зүйн
бичлэгийн зүйл болохынхоо
хувьд бодит баатрын зан авир,
ёс суртахуун, соёл хүмүүж-
лийн доголдлыг харуулдаг,
харин утга зохиолын нэг төрөл
шог өгүүлэгт адилхан уран
сайхны шог, хошин дүр
бүтээдэг боловч тэр нь
зохиомол байдаг.

»

М. Энхболд сайд нарыг огцруулахаар жагсаал цуглаан хийсний улмаас болж цагдаа нөхөр нь Сүхбаатарын талбайд ерөнхийлөгч, ерөнхий сайдыг хамгаалах харуулд зогсож, улмаар хороололд эргүүлд гарахдаа олдог байсан арвин их орлогоо алдах болсон цагдаагийн эхнэрийн өчилийг үзүүлжээ. Арга тасарсан цагдаагийн эхнэр: «Дэлгүүрийн үүдэнд оймс зардаг бүдүүн Урнаа л гэхэд нөхөрт минь өдөр бүр мянган төгрөг өгдөг байлаа. Шаг зардаг галзуу Дулам эгч бол бүр бурзайлгана. Үдэш бүр нэг шил үйлдвэрийн архи өгдөг байсан гээд л бодчих. Гурван мянган төгрөг шүү дээ! Энэ мэтчилэн тоочоод байвал зуугаад хүн бий. Самар зардаг хамгийн ядуу Должин эмээ гэхэд л өдөрт таван зуун төгрөг, нэг аяга самар баталгаатай өргөн барьдаг... "Согтуу сэжиг бүхий этгээдийг заавал нэгжиж шалга" гэсэн даалгавартай юм чинь. Нэг согтуугаас наад зах нь нэг гар утас гарч ирнэ. Ноднин намар нэгэн согтуу бүр хэдэн сая төгрөг хармаалж явсан гээч.

Ёстой нэг бурзайж билээ! Тэгэхэд хөдөлгөөнд оролцож байгаа согтуучууд халаасандаа ядахдаа зуун төгрөг ч үгүй арчаагүй амьтад байна гэсэн. Тэднийг нэгжиж гараа бузарлаад яах вэ дээ, ёстой дараа л байна... Сүхийн талбайн ойролцоох танихгүй хүмүүсээс, тэгээд бас өөр цагдаад оноож өгсөн талбайгаас яаж мөнгө саах вэ? Ядахдаа арвуул хориулаа хамт хөлхөлдөж байгаа болохоор бие биендээ шавар хаагаад, тэр хавийн гудамж талбайг хариуцсан цагдаа хүртэл өөрөө орлогогүй болсон гэнэ лээ» гэхчилэн өчсөнийг шоглон урлажээ. Нөгөө талаас улс төрийн өндөр албан тушаалаас буухгүйн тулд амиа тавих шахаж байгаа улс төрчдийг ч ёгтолсон байна.

Хүнлэг, энэрэнгүй байх нь шог найруулалд тавигдах зарчмын нэг гол шаардлага юм. Хэдийгээр шог найруулал бичлэгийн хурц, дайчин зүйл болохыг судлаачид нэгэн дуугаар хүлээн зөвшөөрдөг боловч үүнийг буруу үйлдэл хийсэн, ёс суртахууны доголдолтой хүнийг яаж ч доромжилж, элдвээр бичиж болдог гэж ойлгож хэрхэвч болохгүй. Шог найрууллын нэрт мастер Б. Цэнддоо: «Доромжлол, хошигнол хоёрын хооронд торгон зурвас бий. Жаахан л хэтрүүлбэл хошигнол нь доромжлол болж хувирдаг» гэж хэлсэн нь сургамжтай. Шог найруулалч «баатар»-ыг хэдий чинээ хүндэтгэнэ, нийтлэлийнх нь хүмүүжлийн ач холбогдол төдий чинээ өндөр байна.

Улс төрийн шог. Улс төрийн шог бол дэлхий дахины тогтмол хэвлэлд дэлгэрсэн бичлэгийн зүйлийн нэг бөгөөд улс төрийн хурц асуудлаар бичигддэг. Улс төрийн шог нь уран элэглэлийн бүтээл бөгөөд улс төрийн

дайсагнагч, сөргөлдөгч үзэл суртал, үйл ажиллагаа, сэтгэл зүй, нийгмийн системийг илчлэн эсэргүүцэх зорилго бүхий сэтгүүл зүйн бичлэгийн нийтлэл-уран сайхны төрөл мөн⁸.

Улс төрийн шогийн олон улсын нэр томъёо нь памфлет юм. «Памфлет» гэдэг нь пам — бүгдийг, флегма — шатаах гэсэн утгатай грек үг билээ. Энэхүү нэр томъёо үлгэр домгоос эхтэй бөгөөд Олимпийн бурхадтай, юуны түрүүнд дайснаудаа аянгаар ниргэдэг Зевс тэнгэртэй холбоотой⁹. Шоглон шүүмжилж байгаа зүйлээ үндсээр нь үгүйсгэн эсэргүүцэх зорилгоор улс төрийн шог бичигддэг нь эндээс илэрхий байна. Бичлэгийн энэхүү зүйлийн онцлог нь хурц мэтгэлцээн бүхий байхын хамт «баатар»-ын жигшүүрт явдал, авирын талаар уншигчдад зэвүүцэх, үзэн ядах сэтгэл төрүүлэх юм. Улс төрийн шогийн хэл нь тэсгэлгүй хурц бөгөөд бичлэг нь зүйрлэл, уран дүрслэл, егөөдөл, хэтрүүлэл зэрэг шоглолын хэрэглүүрийг өргөн ашигладаг.

Английн нийгмийн хурц ширүүн тэмцлийн үеийн утга зохиол нь улс төрийн шогоор баялаг байсан юм. Ялангуяа XVII зууны дундуур Хөрөнгөтний хувьсгалын үеэр тэргүүний үзэл санааг сурталчлах, үеэ өнгөрөөсөн бүхнийг илчлэн шүүмжлэхэд үзэл суртлын гол зэвсэг болсон улс төрийн шогууд чухал үүрэг гүйцэтгэжээ¹⁰. «Хилэнт үгс» хэмээн нэрлэгдэж, утга зохиолд өргөн дэлгэрсэн улс төрийн шог нь Сэргэн мандалтын үеийн энэрэнгүй үзэлтэн Ж. Пожо Браччолини, П. Аретино зэрэг хүмүүсийн тэмцлийн зэвсэг болж байжээ. Роттердамын Эразмын «Тэнэг явдлын дуулал» (1509), У. фон Гуттен, К.

Рубеан нарын «Харанхуй хүмүүсийн захидлууд» (1515-1517) зэрэг бүтээл нь улс төрийн шог дүр төрхөө олоход түлхэц болсон байна.

Улс төрийн шог бичсэн эзэндээ хэчнээн халтай болохыг дараах тохиолдлуудаас харж болно. Оросын түүхэн үүргийг үгүйсгэсэн «Философийн захидлууд»-ыг бичсэнийх нь төлөө нийтлэлч П. Я. Чаадаевыг галзуу хэмээн зарласан¹¹ бол «Тэдний нүүр царай», «Баримтын өмнө», «Пап ламыг нулимаж байна» зэрэг тэсгэлгүй хурц улс төрийн шог бичсэн Зөвлөлт Украины сэтгүүлч Я. А. Галан алагдсан байдаг¹².

Улс төрийн шог нь шог найруулалтай гарал нэгтэй, олон шинжээрээ түүнтэй ойролцоо юм. Гэхдээ улс төрийн шог нь шог нийтлэлийн хамгийн хурц, дайчин хэлбэр болохынхоо хувьд тодорхой баримтыг түшиглэдэг, тиймдээ ч зохиогчийнхоо улс төрийн байр суурийг илчилж байдаг. Хэрэв шог найруулалд аливаа зохисгүй явдал, бурангуй үзэгдлийг тусгахдаа засч залруулах замаар бүрэн арилгах зорилт тавьдаг бол улс төрийн шогт өгүүлж буй зүйл нь эвлэршгүй зөрчил байдаг учраас засч залруулах биш, харин үндсээр нь ховх татахыг зорилгоо болгодог¹³. Түүнчлэн улс төрийн шогч уг үзэгдлийн мөн чанар, эх үүсвэрийг илрүүлж, ул суурьтай задлан шинжлэхийг зорьдог байхад шог найруулалч урдаа ийм зорилго тавьдаггүй бөгөөд түүний илрэлийг шоглодог байна¹⁴.

Оросын судлаач В. А. Моисеев энэ талаар хэрэв шог найруулал анагаах үүрэгтэй бол улс төрийн шог «үхүүлэх» зорилготой гэж тэмдэглэсэн нь угтаа нэг санаа мөн¹⁵. Түүнчлэн М. С. Чере-

пахов бичлэгийн энэхүү хоёр зүйлд баримт ямар үүрэгтэй болохыг тэмдэглэхдээ улс төрийн шогт баримт нь шог найрууллыг бодвол төдийлөн чухал бус, учир нь «хуйхлан устгах шүүмжлэл өрнүүлдэг, тиймээс үзэгдлийг бүхэлд нь үгүйсгэдэг болохоос бус, түүний аль нэг илрэлд халддаггүй»¹⁶ гэжээ. Эндээс үзэхэд улс төрийн шог, шог найруулал хоёрын ялгарах үндсэн шинж нь тусгах объект, түүнд хандах хандлага, бичлэгийн арга юм.

Манай тогтмол хэвлэлд улс төрийн шог цөөн боловч нийтлэгдсээр иржээ. Шог зохиолын нэрт төлөөлөгчдийн нэг Л. Бадарч дөчөөд оны сүүлчээр энэ зүйлээр дорвитой хэд хэдэн нийтлэл туурвисан юм. Тэрээр «Самурайн шинэ эзэд», «Уйлах, инээх», «Американ зүүд ба алтан загасны үлгэр», «Хазгар илжигний түүх» зэрэг улс төрийн шогтоо дэлхий дахиныг дээрмийн аргаар эзэгнэж, хагартлаа баяжих санаархлаа хэрэгжүүлэхийн тулд яахаас ч буцахгүй байгаа эзэд, дайны хэнээтнүүдийн үнэн нүүр царайг уран элэглэлийн аргаар илчилсэн байдаг.

Түүнээс гадна Л. Түдэвийн «Далдын хар дөнгө», «Хөрөнгөтний биеийн байцаалт», «Энээ алдсан захидал» зэрэг нийтлэл улс төрийн шогийн шилдэг жишээнд тооцогддог.

Уран хошин, ухаалаг, цэцэн, үнэн голоосоо инээмээр зохиол цөөрч, нэг үеийг бодвол ёгт үлгэр ховордож, олон улсын сэдэвтэй улс төрийн шог, шог найруулал үгүйлэгдэх болсныг утга зохиол судлаач, шүүмжлэгч Ц. Хасбаатар онцолжээ¹⁷.

Шог, хошин мэдээ. Мэдээ нь сэтгүүл зүйн бичлэгийн төрөл зүйлийн мэдээллийн төрлийн үндсэн зүйл бөгөөд үнэн бодитой, шуурхай, ойл-

гомжтой, товч тодорхой, хүртээмжтэй байх ёстой. Мэдээ бол сонин, сэтгүүлийн бичлэгийн хамгийн эртний, үлэмж дэлгэрсэн үндсэн зүйлийн нэг мөн. Судлаачид мэдээг янз бүрээр тодорхойлдог ч нийгмээрээ заавал сонсож мэдсэн байх ёстой чухал мэдээлэл гэдэгтэй санал нийлдэг. Харин шог, хошин мэдээ гэдэг бол аль нэг шинэ соргог мэдээг хошин маягаар ёжтойгоор өгүүлснийг хэлнэ.

1950-1960-аад оны «Хүмүүжил жигшил»-ийн материалуудыг бичлэгийн төрөл, зүйлээр нь ангилж үзэхэд шог мэдээ томоохон байр эзэлдэг. Тус сэтгүүлийн шог мэдээ гол төлөв аль нэг аймаг, сум, байгууллагад оршиж буй алдаа дутагдалтай үйл ажиллагааг шүүмжлэн бичигдсэн байдаг. Шог мэдээ нь шог найруулалтай бичлэгийн хувьд төстэй боловч хэмжээгээрээ багшаархан, мөн уран сайхны дүр бүтээхийг зорьдоггүйгээрээ ялгаатай юм.

«Хүмүүжил жигшил» сэтгүүлд нийтлэгдсэн «Нүдний гэм» (1961, №3-4) шог мэдээнд Архангай аймгийн нэгдлийнхэн малын сүүг нүдний гэм болгосныг шүүмжлэн мэдээлсэн бол мөн дугаарт нийтлэгдсэн Пүрэвдоржийн «Хүүхэд горьдчихжээ» шог мэдээнд Ховд аймгийн Дөргөн сумын нэгдлийн дарга бага сургуулийн байранд суудаг хүүхдүүдэд аль ноднин жил энэ ертөнцөд байдаг хоол бүхнийг хийлгэнэ гэж амласнаа таг мартаж, гурилтай хоолноос өөр хоол мэддэггүй ахлах тогоочоо ажиллуулсаар байгааг шоглон мэдээлжээ.

Н. Өлзийбадрахын «Анхаараасай» (1961, №5) шог мэдээнд Ховд аймгийн Чандмань сумын өртөөний үйлчилгээний газар аймагтаа адгийн байранд

ордог, халбага сэрээ нь байвал ор дэвсгэрийн хэрэглэл нь хүрдэггүй, энэ нь байвал хоол унд нь байдаггүй зэрэг дутагдлыг шүүмжлэн мэдээлсэн байдаг.

Ёгт үлгэр. Адгуус амьтан болон байгалийн үзэгдэл явдлыг өгүүлэх замаар нийгэм ба хүний алдаа дутагдлыг илрүүлэн шүүмжилсэн шог, хошин зохиолыг ёгт үлгэр гэдэг. Ёгт үлгэр нь үргэлжилсэн, шүлэглэсэн хэлбэртэй байна. Олон үндэстний ёгт үлгэрийн туршлагаас харахад шүлэглэлт өнгө аяс давамгайлсан хандлагатай бөгөөд гол санаагаа далд битүү илэрхийлсэн байдаг. Ёгт үлгэрт хошигнох, шоглох нь гол бус, харин сургамжийн зорилготой байдгаараа онцлог юм. Өөрөөр хэлбэл, ёгт үлгэрт бяцхан явдал гардаг, явдлын цаана ёгтлол нуугддаг, ёгтлолын цаана сургаал оршсон байдаг.

Ёгт үлгэр зохиогдохын үндэс нь эрт цагийн анчин, малчин ард адгуус амьтныг хүнээс ялгах, тэдгээрийн адил төстэй, нийтлэг талыг дүгнэн сэтгэх чадвартай болсонд оршино. Ёгт үлгэр манай эринээс олон зууны өмнө эртний соёлт Египет, Энэтхэг, Грект үүсчээ. Эртний Грекийн Эзопын зохиол, Эртний Энэтхэгийн «Таван шастир» (Панчатантра) нь ёгт үлгэрүүд байсны дээр хожмын Францын Ж. Лафонтен, Оросын И. А. Крылов нарыг дурдаж болно. Манайд хуульч Сандаг, Л. Агваанхайдав, С. Ишсамбуу нарын зохиолч ёгт үлгэр олныг бичсэн байдаг.

Ёгт үлгэр манай хэвлэлийн практикт гучаад оны сүүлч, дөчөөд оны эхэн үеэс бий болжээ. Тодруулбал, Л. Бадарчийн «Баавгай», «Хэрээ, хараа хоёр», Б. Баастын «Гувшаа хурга», «Нэрэлхүү үнэг», Д. Тарваагийн «Хэд-

гэнэ» зэрэг бүтээлийг нэрлэж болно. Тэдгээрт дутагдал доголдлыг амьтны зан үйлээр төлөөлүүлэн үзүүлж байв.

«Матар» сэтгүүлд орчуулгын ёгт үлгэрүүд олноор нийтлэгдэж байжээ. Тухайлбал: 1947 оны дугаар 6-д И. А. Крыловын «Аянга ба аалз», дугаар 7-8-д «Заанд тохиолдсон нэг явдал», «Могой, хөвгүүн хоёрын үлгэр» нийтлэгдсэн байна.

Мөн сэтгүүлийн 1947 оны дугаар 11-12-т Б. Баастын бичсэн «Гувшаа хурга» ёгт үлгэрт:

«...Холбоотой хонины захаар тойрч
Хоньдын доогуур шургаж аваад ...

...хушуу амаар нь сүү цахарч,

Ходоод гэдэс нь цүндийн...» гарч ирдэг гувшаа хургатай адил улсын чухал ажлыг хийхийн оронд өөрийн хар амийг хоохойлж, ашиг завшаан олдог зарим хүмүүсийг шогложээ.

Тавад онд ёгт үлгэр тооны хувьд олширсон төдийгүй, агуулгыг нээх дүрслэлийн арга, зохиолчийн хандлага, санал дүгнэлт зэрэг олон аяс байдлаар илэрхийлэгдэх болжээ. Юуны өмнө гол төлөв хоёр амьтны эсрэг үйлдлийг зэрэгцүүлэн үзүүлсэн нь хэрэг явдлыг тун оновчтой ялгаруулж байна. Ш. Гаадамбын «Хоёр гургалдай», «Зарга шүүсэн нь», «Шоргоолж, царцаа хоёр», Н. Надмидын «Хоёр хулганын яриа», Л. Бямбажавын «Хоньчин ба чоно» зэрэг олон арван ёгт үлгэрийг жишээ татаж болно. Тухайлбал «Хоёр гургалдай» ёгт үлгэрт өөр өөр нутгийн гургалдай дуулах авьяасаа бие биендээ гайхуулж байгаагаар

«Авьяас чадварын үнэлэлтийг
Алдар нэртнээс эрэлтгүй
Өргөн олны үнэлэлтээр
Өвдөг сөхрөн бишрүүштэй»

хэмээн алдар нэрийг өөрөө хөөцөлдөх хэрэггүй, жинхэнэ хэрэгтэй бүхнийг хийж чадсан бол ард түмний сэтгэлд аяндаа хоногшин үлдэнэ гэсэн санааг гаргажээ.

Ёгт үлгэр аль ч нийгмийн үед бичигдэж болдгоороо онцлогтой. Хориотой хууль цаазтай цагт зусар бялдууч, харгис хэрцгий, эрх ямбатай ихэс дээдсийг хорон үгээр далдуур хатган ёгтолдог байсан бол энэ үед ч авлигач, албан тушаал хөөцөлдөгчдийг ёгт үгээр даапаалах болжээ.

Ерээд он гарснаар «Тоншуул» сэтгүүлд А. Амарсайханы «Төсөв» («Тоншуул», 2004, №23, 24), Г. Жамъяндоржийн «Арслан ба амьтад» («Тоншуул», 2004, №23, 24) гэх мэт цөөхөн тооны ёгт үлгэр нийтлэгджээ. Эдгээр ёгт үлгэр бүгд амьдралд байдаг аль нэг бүтэхгүй зүйлийг ёгтлон шоглосон байна. Г. Жамъяндоржийн «Арслан ба амьтад» ёгт үлгэрт бусдыг өөртэйгөө адилхан бодож, тэднийг өөрийн адил байлгах гэж муйхарлан зүтгэгчдийг амьтдаар төлөөлүүлэн тун эвтэйхэн шүүмжилсэн байна. Энэ ёгт үлгэр бичлэгийн арга барилаараа И. А. Крыловын ёгт үлгэрүүдийг санагдуулдаг. Уг ёгт үлгэрийн цаад санаа нь албат иргэд, ард олныхоо амьдралыг мэддэггүй удирдагч тэдний амь зуулгыг өөрийн иддэг уудагтай адилтган бодож байгааг уудлан илчилж, шоглосонд оршиж байна. Дурдвал:

— Хаан Арслан амьтдынхаа
Амьдралтай танилцахаар гарчээ.
Хамгийн түрүүнд тэр
Хавтгайнд очиж таарчээ
Зэрлэг тэмээ хавтгай
Зээргэнэ, бударгана тавгалж
Арааны шүүс асгам
Амттайг нь гайхав.

Саглагар сүүлт хэрмийнхээр орлоо
Өөрийнхөө дуртай зоог самар, жимс
тавилаа

Янгир гуайнд очлоо
Улаан шаргал үүргэнэ
Урьд нь тавьж зочиллоо
Арслан нэгний нь ч тавганд ам
хүрсэнгүй

Хаан Арслан маргааш нь
Хаш ордондоо буулаа гэнэ
«Харагдаж үзэгдэх гачигдаж байгаа
юм.

Гав ганцхан байна.
Хавтгай, Янгир тэднийг
Махан хоолоор хангасугай» гэжээ
гэхчилэн өгүүлнэ.

Элэглэл. Элэглэл нь хэн нэг нэр
цуутай хүн, түүний ажил үйлс, авир
зангийн онцлог, зохиол бүтээлийнх нь
чанар чансаа, донж маяг хийгээд дуу
хоолой, дадал зуршил, гарал үүсэл,
байр суурь гэх мэт онцлогийг нийтэд
дэлгэх зорилгоор нөхөрсгөөр тохуурхан
бичсэн хүндлэл, зэмлэл, шүүмжлэл,
ингүүн егөөний өнгө аястай бяцхан
шүлэг мөн.

Элэглэл бол шог зохиолын бичил
хэлбэр бөгөөд гол төлөв уран бүтээл-
чид бие биедээ зориулж бичсэн бай-
даг. Элэглэлд тухайн уран бүтээлчийн
бүтээлийн онцлог, арга барил, хэллэг,
зан чанарыг голчлон илэрхийлсэн
байхын зэрэгцээ түүний сул, дутагдал-
тай талыг ёгт хошин, хоргүй байдлаар
инээд наргиантайгаар дайруулан
гаргасан байдаг. «Нэг үгээр хэлбэл
уншаад уйлмаар байвч инээхээс
аргагүй, уурламаар байвч баярлаад
өнгөрөхөөс аргагүй байдалд дүрсэлсэн
зориулал зохиол» гэж судлаач Д.
Галбаатар тодорхойлсон байдаг¹⁸.

Элэглэл бол тогтмол хэвлэлийн
практикт нэлээд дэлгэрсэн бичлэгийн

жижиг зүйл бөгөөд шүүмжлэлт санааг
нөхөрсөг наргианы хэлбэрээр илэр-
хийлдэг, тодорхой хүнд хаяглагдсан
шүлэг юм. Утга зохиол судлаачид
түүнийг урлагийн хамгийн эртний
төрөл, зүйлийн нэг гэж таамагладаг.
Хэрэв анхааралтай ажиглах юм бол их
урлагийн аль нь ч элэглэлгүйгээр төгс
төгөлдөр болж чаддаггүйтэй адил улс
төр, гүн ухааны маргаан мэтгэлцээн ч
элэглэлийг өргөн ашигладаг. Элэглэл
голдуу хүн, түүний үйл ажиллагаанд
чиглэдэг ба хөгтэй инээдэмтэй талыг
нь дуурайн шоолох аргыг өргөн
хэрэглэдэг.

Орчин үед элэглэл нь сонин,
сэтгүүлийн хуудсанд хааяа
тааралддаг шог, хошин зохио-
лын жижиг зүйл төдий биш, харин
сэтгүүл зүйн бичлэгийн идэвхтэй
хэлбэр болж төлөвшсөн байна. Энэ нь
голдуу төр нийгмийн зүтгэлтэн, урлаг
соёлын алдартнуудыг нөхөрсгөөр
шүүмжлэх, «чимхэх» шаардлагаар бий
болдог. Элэглэл бичихэд хэтрүүлэл,
егөөдөл, багасгал, жигтэй явдлыг өргөн
ашигладаг. Хэтрүүлэл нь хүний зан
байдлыг өсгөж даваадуулснаар, егөө-
дөл нь хүний нүүр царайны хувирал,
хүсэл бодлыг тодруулснаар, багасгал
нь аугаа их худал хуурмагийн утга
учрыг багасгаснаар, жигтэй явдал нь
хүний хийж болох үйлдлүүдийн эсрэг
чиг шугамыг онцолсноор тус тус
илэрдэг байна.

1990 оноос хойшх үеийн «Тон-
шуул»-ын байнгын «зочин»-ы нэг нь
элэглэл байв. Тус сэтгүүлийн 2002 оны
дугаар 14-т элэглэлүүд нөхөрсөг шог
зургийн хамт нийтлэгджээ. Ардын уран
зохиолч Тангадын Галсанг:

«...Дөмөг дөрвөн мөрт уншаад
Тээр жил түрүүлсэн юмсан.

Домог болоо шив дээ янз нь...
 ... Болор цом хүртсэн юмсан
 Түүх болоо шив дээ та минь
 Харин сүүлд ажаад байхад
 Хар савхин дээл өгөх болж
 ... Бор эсгийгээр хийсэн
 Бойтог өгдөг болбол
 Бодох юмгүй ах нь өрсөлдөнө
 Өвгөн хүнд тохирно
 Өвдөг хавиас дулаан» гэхчилэн
 элэглэсэн байхад Төрийн шагналт яруу
 найрагч Зундуйн Доржийг:

«...Эгц урдаас нь харахад
 Еврей юм шиг Дорж
 Элдэв ааш араншин нь
 Европ юм шиг Дорж
 Эргэл хоргол нүд нь
 Эмэгтэй хүн шиг Дорж
 Ногт гүйлгээд баригдвал
 Ноцоод авах Дорж
 Хазаарын солионд тааралдвал
 Ханцуйтай нь гавлах Дорж
 Найраг дууны тэнгистээ
 Номонд нэвтэрсэн Цорж
 Ногоон сархданд унавал
 Номхон далайн Морж» хэмээн
 нөхөрсөгөөр элэглэжээ.

Ц. Байды, Ц. Жандал нар нөхөрсөг
 шог зургийг нь зурсан шог зохиолч Ж.
 Сарантуяагийн «Шогч нөхдөө эргэн
 дурсахуй» (2002, №15) элэглэлүүд нь
 мөн л донжтой болсон ажиглагдана.
 Тэрээр жүжигчин Т. Латиф, М. Цэвээн-
 равдан, Цээеэ, найруулагч Г. Доржсам-
 буу, зохиолч Жам. Шагдар нарыгаа
 нөхөрсөгөөр дурсчээ.

А. Бат-Эрдэнэ нөхөрсөг шог зургийг
 нь зурж, уран элэглэгч И. Цэрэнжамц,
 М. Дэмчиг нарын «Ахмадууддаа сар
 шинийн мэнд дэвшүүлье!» (2003, №2)
 мэндчилгээ нийтлэгджээ.

Шог яриа буюу онигоо. Хувь хүний
 болон нийгмийн элдэв гэм дутагдлыг

оновчтой шоглон шүүмжилсэн, эсвэл
 амьдралд тохиолдсон хөгтэй явдлыг
 хошигнон өгүүлсэн агуулгатай, уран
 хошин төгсгөлтэй бага шиг хэмжээний
 аман өгүүллэгийг шог яриа гэнэ¹⁹. Шог
 яриа нь уран хошин зохиомжид
 тулгуурлан, чиглэсэн нэг санаагаа товч
 тодорхой, инээдэмтэйгээр илэрхийл-
 дэг, ихэвчлэн хоёроос илүүгүй баатрын
 харилцан ярианы хэлбэрээр бичигдсэн
 шог, хошин зохиолын хамгийн жижиг
 зүйл юм.

Богино хэмжээний шог, хошин
 бичлэгийг төлөвшүүлсэн явдал
 бол Монголын утга зохиолын
 чухал ололтын нэг мөн. Манай ард
 түмэн эрт үеэс ухаалаг, хэрсүү
 инээдээр нийгмийн өө гажгийг илчилж
 ирсэн баялаг уламжлалтай юм. Хүний
 саруул ухаан, өөдрөг сэтгэлээс эх
 ундаргаа авсан цэцэн цэлмэг, мэргэн
 ончтой инээд ямагт нийгмийн шинжтэй
 байж, хүний эрхэм дээд эрмэлзэлд
 үйлчилж, сайныг дэмжин дэлгэрүүлэх,
 саарыг жигшин арилгах хамгийн хүчтэй
 зэвсэг болсоор иржээ. Судлаач Д.
 Боролзойн ажигласнаар монгол шог,
 хошин яриа заримдаа үгийн тоглоом
 байх ч шоглолын гол хүч нь хурц ухаан,
 цаг үеэ олсон байдал, аман зохиолын
 шинжийг бүрэн хадгалсан байдаг
 оршдог байна²⁰.

Шог яриа нийгмийн бүх давхаргад
 зориулагддаг бөгөөд ахуй, нийгэм, улс
 төр, янаг амраг, бадарчны, хүүхдийн
 гэх мэт олон төрөл зүйлтэй. Онигоог
 мөн шүүмжлэлт хошин ёгт зохиолын
 төрөл гэж болох ба аман, бичгийн хоёр
 хэлбэрээр маш өргөн хүрээнд
 дэлгэрсэн байдаг.

1940-50-иад оны үеэс шог, хошин
 хэвлэлд ёс суртахууны сэдэвтэй шог
 яриа нийтлэгдэх болжээ. Ялангуяа

дайны цаг үеийн байдлыг харуулсан шог яриаг уран бүтээлчид их сонирхон бичиж байсан нь ухуулга сурталчилгааны үүрэгтэй байв. Тухайлбал: зохиолч Д. Даржаа «Германы фашистын нэг цэрэг нөгөөдөө ярьсан нь» (1942) шог яриандаа бусдын нутагт шунахайран түрэмгийлээд ядарч зүдэрч яваа дайсны арчаагүй байдал, аймхай хулчгар зан төрхийг харуулсан байна:

— Морин цэрэг байхгүй минь яав даа.

— Яагаад тэр билээ?

— Морин цэргүүд амар юм. Өлсвөл морио иднэ, зугатвал хурдан ухарна.

Монголын аман болон бичгийн зохиолоос сэтгүүл зүйн

өвлөн авсан үнэт зүйлийн нэг нь богино хэмжээний шог, хошин зохиол мөн. Ийм зохиол нь олон зүйл, хэлбэртэй байхын дээр маш товч тодорхой өгүүлэмжтэй учир сонин хэвлэлд нийтлэхэд тохиромжтой байдаг.

Хувьсгалт хэвлэлд шог, хошин нийтлэл үүсэхдээ эхлээд ардын авьяастнуудын шоглож, хошигнож, цэцэлсэн шог яриа, явган үлгэрийг шууд ашиглаж байснаа яваандаа тэдгээрийн хэлбэр, зохиомжийг шинэ агуулга, үзэл санаагаар баяжуулсан байна.

Монголын хувьсгалт хэвлэлд шог яриа төлөвшихөд Ч. Ойдов, Д. Даржаа, Ц. Цэдэнжав, Л. Бадарч нарын ахмад сэтгүүлч их үүрэг гүйцэтгэсэн юм. Тэдний халааг М. Гүрсэд, Н. Иштавхай, Шаг. Цэнд-Аюуш, Ж. Барамсай, И.

Цэрэнжамц, Б. Цэнддоо нар залган авчээ.

Шог яриаг сонин, сэтгүүлүүд олноор нийтэлж, богино хэлбэрийн шог зохиолын уралдааныг үе үе зарлаж дүгнэх, эмхтгэл, түүвэр хэвлэх, Инээдмийн өдөр тэмдэглэх зэрэг ажил зохиож заншсаны үр дүнд шог яриа элбэгшсэн юм. Түүнчлэн гадаадын

шилдэг шог яриаг орчуулан нийтлэх хэмжээ өссөн нь манай шогчдын ур чадварт нөлөөлсөн байна.

Хэт явцуу, эсвэл найз нөхдийн хүрээнд хэлэлцмээр, түүнчлэн бүдүүлэг утга санаатай онигоог нийтийн хэвлэл мэдээллээр дамжуулахад зохисгүй бай-

даг. Бас нэг анхаарах зүйл бол онигоо шинэ сэргэг байвал хүнд илүү амар хүрдэг. Үе үе дамжиж, улиг болсон шог яриаг «Сахалтай онигоо» гэж ярьдаг нь олон нийт шинэлэг зүйлийг хүсч хүлээж байдгийн илрэл мөн.

«Матар», «Хүмүүжил жигшил» сэтгүүлд харьцангуй цөөхөн, нэг дугаарт 2-5 шог яриа нийтлэгдэж байсан бол орчин үеийн «Тоншуул» сэтгүүлийн нэг дугаарт 30 гаруй шог яриа нийтлэгдэж байжээ.

Ишлэл

¹ 1970. Газетные жанры. М., с. 138-165.

² Чойсамба Ч. 2006. Сонирхолтой сэтгүүл зүй. УБ., 48-49 дэх тал.

³ Зулъякафиль М. 2005. Сэтгүүл зүйн тайлбар толь. УБ., 257-258 дахь тал.

⁴ Шостак М. 1999. Ироничный журналист // «Журналист», №5-6, с. 59.

- ⁵ Вакуров В. Н. 1981. О языке советского фельетона // Стилистика газетных жанров. М., с. 126-127.
- ⁶ Виленский М. Э. 1982. Как написать фельетон. М., с. 62; Ворошилов В. В. 2001. Журналистика. СПб., с. 147.
- ⁷ Норовсүрэн Л. 2003. Монголын сэтгүүл зүйн түүхэн тойм. Гутгаар боть. УБ., 243 дахь тал.
- ⁸ Норовсүрэн Л. 2005. Сэтгүүл зүйн бичлэгийн төрөл, зүйл. УБ., 240 дэх тал.
- ⁹ Ткачев П. И. 1975. Иду на «вы»: заметки о памфлете. Минск, с. 7.
- ¹⁰ Прохоров Е. П. 2002. Введение в теорию журналистики. М., с. 26.
- ¹¹ Беспалова А. Г., Корнилов Е. А., Короченский А. П., Лучинский Ю. В., Станько А. И. 2004. История мировой журналистики. Изд. 3-е. Ростов-на-Дону, с. 140.
- ¹² Ворошилов В. В. 2001. Журналистика. СПб., с. 148-149.
- ¹³ Ким М. Н. 2004. Жанры современной журналистики. СПб., с. 23.
- ¹⁴ Мельник Г. С., Тепляшина А. Н. 2006. Основы творческой деятельности журналиста. Изд-во «Питер», с. 150.
- ¹⁵ Моисеев В. А. 2002. Журналистика и журналисты. Киев, с. 198.
- ¹⁶ Черепанов М. С. 1984. Таинства мастерства публициста. М., с. 122.
- ¹⁷ Хасбаатар Ц. 1989. Шог, хошин зохиолын тухай // Уран зохиолын тэмдэглэл. УБ., 35 дахь тал.
- ¹⁸ Галбаатар Д. 2008. Уран зохиолын онолын ойлголт, нэр томъёоны тайлбар толь. Токио, 158 дахь тал.
- ¹⁹ Гадамба Ш., Цэрэнсодном Д. 1978. Монгол ардын аман зохиол. УБ., 294 дэх тал.
- ²⁰ Боролзой Д. 2000. Монгол шог, хошин ярианы төрөл, зүйлийн асуудалд // «Уран зохиол судлал» эрдэм шинжилгээний сэтгүүл, 179 дэх тал.
4. Чойсамба Ч. 2006. Сонирхолтой сэтгүүл зүй. УБ.
5. Белинский В. Г. 1944. О Крылове: Сборник статей и высказываний. М.
6. Беспалова А. Г., Корнилов Е. А., Короченский А. П., Лучинский Ю. В., Станько А. И. 2004. История мировой журналистики. Изд. 3-е. Ростов-на-Дону.
7. Виленский М. Э. 1982. Как написать фельетон. М.
8. Ворошилов В. В. 2001. Журналистика. СПб.
9. 1970. Газетные жанры. (Под ред. В. Д. Пельт, М. С. Черепанова, Ю. Н. Чернышёва.) М.
10. Ким М. Н. 2004. Жанры современной журналистики. СПб.
11. Мельник Г. С., Тепляшина А. Н. 2006. Основы творческой деятельности журналиста. Изд-во «Питер».
12. Моисеев В. А. 2002. Журналистика и журналисты. Киев.
13. Прохоров Е. П. 2002. Введение в теорию журналистики. М.
14. Стрельцов Б. В. 1983. Фельетон. Изд-во БГУ. Минск.
15. Тертычный А. А. 2002. Жанры периодической печати. М.
16. Ткачев П. И. 1975. Иду на «вы»: заметки о памфлете. Минск.
17. Черепанов М. С. 1984. Таинства мастерства публициста. М.

Summary

The theme of humoristic and satirical works in different periods was scarce. The themes were lazy, irresponsible workers, alcoholics, smokers and the people, who kept slow pace in the development of the society and the citizens, who put themselves forward to the socialist country and the satire was fully devoted on those «dreadful» people. Moreover, the theme on morale, bureaucracy, crime (including theft, robbery, violence) were reflected on the pages of «The Crocodile», «The Nurturing, Disgust» and «The Woodpecker» magazines. During the development process Mongolian humor and satire have been in more than 10 types and genre of writings.

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Гүндалай Ш. 2005. Монгол шог, хошин өгүүллэг. УБ.
2. Зулькафиль М. 2005. Сэтгүүл зүйн тайлбар толь. УБ.
3. Норовсүрэн Л. 2008. Сэтгүүл зүйн бичлэгийн төрөл, зүйл. УБ.